

**“АРИГ ГАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

**2019 он**



## **КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**

Эх орны үнэт түүхий эд болох Монгол ямааны ноолуур, тэмээний ноосыг бүрэн боловсруулж, техник технологийнхоо түвшинг байнга сайжруулах замаар гадаад, дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хамт олныхоо ашиг, орлогыг нэмэгдүүлж эх орныхоо хөгжил, дэвшилд хувь нэмэр оруулах нь манай компанийн эрхэм зорилго мөн.



## Агуулга

Ариг гал ХК-ийн ерөнхий танилцуулга

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын тогтоол

Ариг гал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

Ариг гал ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа,  
санхүүгийн үйл ажиллагааны талаарх  
Гүйцэтгэх захирлын тайлан

Ариг гал ХК-ийн 2018 оны жилийн эцсийн  
санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд  
ТУЗ-өөс өгсөн дүгнэлт

Ариг гал ХК-ийн ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга

# Компанийн ерөнхий танилцуулга

“Ариг гал” ХК нь анх “Ээрмэл”-ийн үйлдвэр нэртэйгээр 1981 онд ОХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар байгуулагдсан. Монголын ноосны салбарын Нэхмэл,Сүлжмэлийн 1,2-р үйлдвэрүүд, Улаанбаатар, Эрдэнэт, Дорнодын хивсний үйлдвэрүүдийг цэвэр болон хагас ноосон утсаар100% хангах чиглэлээр жилдээ 3500тн 3-42 номерын хагас болон цэвэр ноосон ээрмэл хийх хүчин чадалтайгаар ашиглалтад орсон болно.

1990он хүртэл бүрэн хүчин чадлаараа ажиллаж, дотоодын ноосны салбарын үйлдвэрүүдийг бүрэн хангаж байснаас гадна цэвэр ноосон ээрмэлийн 40-өөд хувийг Болгар, Афганистан улсад экспортод гаргаж байлаа.

1991 оны 6 сард МУ-н ЗГ-н ӨХК-н 61 тоот тогтоолоор хувьчлагдаж төрийн оролцоогүй 100%-н “Хувьцаат Компани” хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд одоо 7881 хувьцаа эзэмшигчтэй, хувьцааны 60 гаруй хувийг компанийн ажиллагчид эзэмшдэг.

Зах зээлийн шилжилтийн 1990-1996 онуудад дотоодын хэрэглэгч үйлдвэрүүд зах зээлгүйгээс бүгд зогсч хонины уртын ноосоор хийсэн ээрмэл дотоод хэрэглээгүй болсноос гадна Афганистанд дайны байдал үүсч, социалист систем задарч Болгарын экспорт зогссон зэргээс гадаад зах зээл ч хаагдаж ноосон ээрмэлийн үйлдвэрлэл бүрэн зогссон байна.

Энэхүү зах зээлийн шилжилтийн бэрхшээл, хувьчлалын дараах өөрчлөлтийн хүнд үед ажил амьдралаа үйлдэртэйгээ холбосон мэргэжлийн олон зуун ажилчид, тэдний ар гэрийн амьдралыг баталгаатай байлгахад нийгмийн өмнө Монгол улсын өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, Монгол Улсын үндэсний үйлдвэрлэлийг хэвээр хадгалан үлдэх зорилгоор 1991 онд Японоос ноолуурын хялгас ялгах шугамыг худалдан авч шинэ зах зээлд зохицох шинэчлэлтийг цаг хугацаа алдалгүй хийж, хялгасыг ялгасан ноолуурыг Япон, Сингапур, Итали, Англи улсуудад экспортолж эхэлсэн.

1993-1997 онуудад АНУ-тай хамтарсан хонины ноосон сүлжмэлийн үйлдвэрлэлийн “МоАмКо” ХХК-ийг байгуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргасан. Мөн 1997 онд Итали улстай хамтарсан ноолуурын хялгас ялгах “Монгол” “Кашмер Файн” ХХК-ийг байгуулж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлсэн.

Шинээр байгуулсан хамтарсан компаниуддаа мэргэшсэн ажилчидаа шилжүүлэн ажиллуулснаар нэг ч ажилчныг ажлын байргүй үлдээгээгүй хадгалж үлдсэн.

1997 онд угаах үйлдвэрлэлийн чиглэлээр “Мон Мяндас” ХХК-ийг 2000 онд тэмээний ноосны хялгас ялгах болон ээрэх шугамыг 2002 онд нэхмэлийн үйлдвэрлэлийг, 2004 оноос сүлжмэлийн утас ээрэх шугамыг тус тус суурилуулж, “Мон Мяндас” ХХК-ийг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх

чиглэлээр үйл ажиллагааг өөрчлөн шинэчиллээ.


2009 онд “Ариг Гал” ХК нь 100% хөрөнгө оруулалттай “Кашмер Холдинг” ХХК-ныг байгуулж нэхэх, сүлжих, зөөлөн оёдол, ширмэл, утас үйлдвэрлэх үйлдвэрлэлийг 800 гаруй ажилтантайгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод гадаадын зах зээлд гаргаж байна.

2007-2014 онуудад зэрэх, сүлжих үйлдвэрлэлийг өргөтгөх, улмаар нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулах иж бүрэн үйлдвэрлэлийг бий болгож, бүтээгдэхүүний хэрэглээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор европын өндөр технологийг бий болгож 100% зөвхөн өөрийн хөрөнгөөр бий болгож чадсан Монгол Улсын цорын ганц компани болж чадлаа.

2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа хэлэлцэж шийдвэрлэсэнээр 2014 оны 06 дугаар сараас эхлэн компанийн оноосон нэрийг “Ариг Гал” ХК болгож өөрчилсөн болно.

Тус компанийн үндсэн үйл ажиллагаа нь барилга, инженерийн байгууламжийн үйлчилгээ, барилгын түрээс, барилгын засвар, шохойн чулуу олборлох хөрөнгө оруулалт хийх гм менежментийн толгой компаниар ажиллаж байна.





" АРИГ ГАЛ "  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар  
сарын 11- ны өдөр

Дугаар 07/19

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам"-ын 2.2 –д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1."Ариг гал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04-р сарын 26-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.3. 2018 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилах ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг батлах.

2.4 АГ ХК-ийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2019 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах

3. Компанийн оршин байрлах хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн компанийн дүрмийг хэлэлцэж батлах.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д мэдэгдэх өдрийг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2018 оны 3 дугаар сарын 15 болон 4 дугаар сарын 01-ний өдрүүд байхаар тогтоосугай.

5.Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, мөн өдрөөс хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2018 оны 3 дугаар сарын 15 болон 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;

6.2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;

6.3.Хурлын санал хураах хуудас.

6.4 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга

6.5 ТУЗ-ийн болон ХЭХ-ын 2019 оны зардлын төсөв

6.6 Хувьцаа эзэмшигчдэд 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тухай ТУЗ-ийн 06/19 тоот тогтоолыг ХЭХ-аар хэлэлцүүлж дэмжүүлэх

- 6.7 Ариг гал ХК-ийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төсөл
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхбатыг, хурлын тооллогын комиссын даргаар Д.Даваасүрэнг томилсугай.
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Мөнхбат/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.БОЛД

Б.АЮУШ

Б.ЁНДОНЖАМЦ

Э.БЯМБАЖАВ

Д.ГИВААПИЛ

С.АПИМАА

Д.МӨНХБАТ



“АРИГ ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДЭГ

Хугацаа: 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17.00 цагт

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Ариг гал” ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайлан  
Илтгэгч нь: Тэргүүн дэд захирал А.Төмөр очир (15 мин)
2. “Ариг гал” ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулах  
Илтгэгч нь: ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Д.Мөнхбат (10 мин)
3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох талаар нэр дэвшигчдийг танилцуулах. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн Э.Бямбажав (15 мин)
- 4 Компанийн 2019 оны ашгаас Ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлэх ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (10 мин)
5. Компанийн удирдлагын 2019 оны зардлын төсөвийг танилцуулах  
ТУЗ-ийн даргын ажлын албаны стратеги төлөвлөлтийн албаны ерөнхий менежер Д.Мөнхбаатар (10 мин)
6. Компанийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулах ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (15 мин)
7. Хурлаар хэлэлцэх асуудлаар санал шүүмжлэл асуулт хариулт явуулах  
Хурлын дарга Д.Мөнхбат (хүн тус бүрт 3-5 мин-аар хурлаас тогтоох)
8. Хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар санал хураалт явуулах, дүнг ХЭХ-д танилцуулах  
Тооллогын комиссын дарга Д.Даваасүрэн
9. Хурлаас гарсан шийдвэрийг хэлэлцүүлж батлуулах  
Хурлын дарга Д.Мөнхбат (цаг тогтоохгүй)

Хурлыг хуралдуулах нийт хугацааг ХЭХ-аас тогтооно



"Ариг гал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар  
хувьцаа эзэмшигчдээс **САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог:.....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн регистрын дугаар:.....

Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо:.....

Хурал хуралдах хугацаа: 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр. 17.00 цагт

Хурал хуралдах хаяг: ХУД.15-р хороо. Зайсангийн гудамж. Үйлдвэрийн парк 18-01 тоот байр. Хурлын танхимд

дд	хуралд оруулж буй асуудал	хурлаас гарах шийдвэр	зөвшөөр сөн (+)	татгалз сан (-)	санал
1	Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсож хэлэлцэх	тайланг батлах			
2	Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэх	дүгнэлтийг батлах			
3	Төлөөлөн Удирдах Зөвлөлийг сонгох				
<b>А</b>	<b>Энгийн гишүүд</b>	ТУЗ-ийн энгийн гишүүдийг сонгож батлах			
1	С.Мөнхжаргал				
2	Д.Гиваапил				
3	Д.Мөнхбат				
4	Сэ.Алимаа				
5	Х.Хания				
6	Б.Ёндонжамц				
<b>Б</b>	<b>Хараат бус гишүүд</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгож батлах			
1	Б.Болд				
2	Б.Аюуш				
3	Э.Бямбажав				
4	2018 оны НА-ыг нэгж хувьцаанд 32.49₮ буюу нийт 109.3 сая.төг (нэг зуун есөн сая гурван зуун дөчин гурван мянга гурван зуун)-өөр тооцож олгох тухай хэлэлцэх	2019 онд зарлаж олгох			
5	2019 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэх	зардлын төсвийг 54236.0 мян.₮-өөр батлах			
6	Ариг гал ХК-ийн оршин байрлах хаягийн өөрчлөл тийг тусгаж шинэчилсэн дүрмийг хэлэлцэж батлах	Дүрмийг батлах			

Саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 04 сарын 26 -ний өдрийн 12.00 цаг

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....(.....)  
( гарын үсэг ) (овог нэр)

Саналын хуудсыг хүчинтэй (хүчингүй)-д тооцож тоолсон, тооллогын комиссын дарга:.....(Д.Даваасүрэн)

(доогуур нь зурах)

Гишүүд: .....(.....)

.....(.....)



Ариг гал ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд

Гүйцэтгэх захирал Х.Ханиягийн тайлан

Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Уламжлал ёсоор “Ариг гал” ХК –ийн хувьцаа эзэмшигчиддээ, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс, өнгөрсөн хурлаас хойш хийсэн ажил, тавьсан зорилгоо хэрхэн хэрэгжүүлснээ өнөөдөр тайлагнаж байна.

Тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас өмнөх хурлаар дэвшүүлсэн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан явуулж, “Ариг гал” группийн харъяа компаниудын дүнгээр 35,7 тэрбум төгрөгийн орлоготой, 1,1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, үйлдвэрлэлд 4,1 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалт хийж, шинээр 360 гаруй ажлын байрыг бий болгож, Улсын төсөвт 4,0 тэрбум гаруй төгрөгийн татвар шимтгэлийн орлого төвлөрүүлж, өмнөх оноос орлого 18%-иар, хөрөнгө оруулалт 2 дахин, улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө 60%-иар өсгөж ажиллалаа.

### **Нэг. Борлуулалтын орлогын талаар**

Манай компани түрээсийн орлого, ноогдол ашиг гэсэн хоёр үндсэн эх үүсвэрээс орлогоо бүрдүүлдэг. Өнгөрсөн онд хуралдсан бүх гишүүдийн хурлаас 2018 онд 2315,0 сая төгрөгийн орлоготой байхаар төлөвлөсөнөөс 5,017,2 сая төгрөг буюу төлөвлөсөнөөс 116,7%-иар өссөн биелэлттэй байна. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 197,5%-иар өссөн байна. Гол нөлөөлсөн орлого нь ноогдол ашгийн орлого юм. Түрээсийн орлого 386,3 сая төгрөгт хүрч төлөвлөсөнөөс 28,7%, өмнөх онтой харьцуулахад 28,1%-иар өссөн. Харин ноогдол ашгийн орлого 4,6 тэрбум төгрөг буюу төлөвлөсөнөөс 130,8 %-иар өссөн биелэлттэй байна. 2018 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Ариг гал ХК-ийн 2017, 2018 оны орлого, үр дүнгийн харьцуулалт /мян.төг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны		2018 оны		2019 оны
		төлөвлөлт	гүйцэтгэл	төлөвлөлт	гүйцэтгэл	төлөвлөлт
<b>I.</b>	<b>Борлуулалтын орлого</b>	<b>1,040,000.0</b>	<b>1,686,698.9</b>	<b>2,315,000.0</b>	<b>5,017,185.4</b>	<b>2,415,000.0</b>
1	Түрээсийн орлого	240,000.0	301,510.3	300,000.0	386,294.8	400,000.0
2	Бусдаас авсан ногдол ашиг	800,000.0	1,670,336.9	2,000,000.0	4,616,412.8	2,000,000.0
3	Бараа борлуулсаны орлого		963.7	-	-	-
4	Бусад орлого		14,638.7	15,000.0	14,477.8	15,000.0
<b>II</b>	<b>Зардлын дүн</b>	<b>839,605.0</b>	<b>1,522,357.0</b>	<b>1,982,866.5</b>	<b>1,478,491.5</b>	<b>1,775,582.0</b>
1	Цалин	261,991.2	172,774.8	251,195.0	231,713.1	251,000.0
2	НДШ	31,438.9	24,479.6	29,783.4	22,759.9	28,865.0
3	Шууд/холбоо	8,598.0	6,465.4	10,550.0	6,389.5	8,550.0
4	Хангамж.матер	4,192.1	3,056.1	4,192.1	9,045.3	3,887.0
5	Ашиглалт.зард	500.0	130,936.6	132,000.0	137,947.6	132,000.0
6	Албан томилолт	15,200.0	1,956.8	15,200.0	517.0	15,200.0
7	Хөрөнгийн элэгдэл		124,315.8	125,000.0	9,675.0	125,000.0
8	Хурлын зардал			2,100.0	1,634.0	2,100.0
9	Бусад зардал	213,065.0	161,134.5	210,966.0	180,609.4	207,100.0
10	БГАҮйлчилгээ	100,000.0	107,854.8	100,000.0	63,466.6	100,000.0
11	Маркетинг, сурталчилгаа	9,500.0	-	9,500.0	-	9,500.0
12	Сур/т.зардал	3,900.0	-	3,900.0	818.0	3,900.0
13	Түлш , тээвэр	9,240.0	6,560.9	8,480.0	7,062.7	8,480.0
14	Зээлийн хүү	154,979.7	757,600.8	1,050,000.0	698,446.2	850,000.0
15	Үйл ажиллагаа-ны бус зардал	27,000.0	25,220.9	30,000.0	108,407.2	30,000.0
16	Валютын ханш ашиг/алдагдал				(3,073,269.9)	

## Хоёр.Санхүүгийн байдлын талаар

2018 оны тайлан балансыг харахад үйл ажиллагааны зардлаа 606,3 сая төгрөгөөр буюу 40,3%-иар багасгасан явдал юм. Үүний гол шалтгаан нь зээлийн хүүгийн зардал 59,2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаа 44,4 сая төгрөгөөр, мөн хөрөнгийн элэгдлийг 114,6 сая төгрөгөөр тус тус бууруулсан, харин өссөн зардал нь цалингийн зардал 58,9 сая төгрөг, бусад зардал 19,5 сая төгрөг өссөн байна.

Санхүүгийн тайлан балансаас харахад өнгөрсөн 2018 онд төлөвлөсөн зардлаас 2,9%-иар бууруулсан нь зардлаа хэмнэх бодлого явуулсан нь харагдаж байна. Ноогдол ашгийн орлого 4,6 тэрбум төгрөг орж ирснээр ЧХБанкны үндсэн зээл 1,7 тэрбум төгрөгийг хүүтэй нь хамт төлж дуусгасан бөгөөд бусад зээлүүдээс 6 харилцагчийн зээлийг төлж дуусгавар болгосон.

Балансын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хураангуй балансаас харна уу.

### АРИГ ГАЛ ХК-ИЙН 2018 оны жилийн эцсийн БАЛАНС

(мян.төг-р)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл		Өсөлт бууралт	
	Эхний	Эцсийн	дүнгээр	хувиар
<b>А.ХӨРӨНГӨ</b>				
1. Эргэлтийн хөрөнгийн дүн	36,140,880.1	36,592,342.2	451,462.10	1.2
Үүнд:Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	338,324.6	216,261.0	(122,063.60)	-36.1
Авлага	35,778,496.8	36,346,400.4	567,903.60	1.6
Үндсэн туслах материал	24,058.7	29,680.8	5,622.10	23.4
2. Биет хөрөнгийн дүн	2,868,525.3	2,945,485.9	76,960.59	2.7
3. Биет бус хөрөнгийн дүн	98,407.6	473,676.5	375,268.90	381.3
4. Урт хугацаат хөрөнгө оруулалт	23,813,334.3	20,873,089.9	(2,940,244.40)	-12.3
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>62,921,147.3</b>	<b>60,884,594.5</b>	<b>(2,036,552.8)</b>	<b>-3.2</b>
5.Богино хугацаат өр төлбөр	47,882,947.8	49,703,003.4	1,820,055.60	3.8
6. Урт хугацаат өр төлбөр	1,899,291.1	160,818.1	(1,738,473.00)	-91.5
7.Хувьцааны дүн	347,932.0	347,932.0	-	0.0
8.Халаасны хувьцааны дүн	(9,142.8)	(9,142.8)	-	0.0
9.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,598,730.6	6,598,730.6	-	0.0
10. Хуримтлагдсан ашиг	6,052,927.8	3,633,951.8	(2,418,976.00)	-40.0
11. Тайлант үеийн ашиг	148,460.8	449,301.4	300,840.60	202.6
12. Эзэмшигчийн өмчийн дүн	13,138,908.4	11,020,773.0	(2,118,135.40)	-16.1
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>62,921,147.3</b>	<b>60,884,594.5</b>	<b>(2,036,552.8)</b>	<b>-3.2</b>

Орлогын тайлан

Санхүүгийн үзүүлэлт	(мян.төг-р)		Өсөлт бууралт	
	2017 он	2018 он	дүнгээр	хувиар
1.Борлуулалт	304,578.1	304,578.1	-	0.0
2.Борлуулалтын хөнгөлөлт, урамшуулал			-	
3.Цэвэр борлуулалт	304,578.1	357,932.6	53,354.50	17.5
4.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,462.1	-	(1,462.10)	-100.0
<b>Ашиг</b>	<b>303,116.0</b>	<b>357,932.6</b>	<b>54,816.60</b>	<b>18.1</b>
5.Үйл ажиллагааны зардал	1,497,136.1	893,486.7	(603,649.40)	-40.3
6.Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	1,343,940.1	986,303.3	(357,636.80)	-26.6
Үүнд: Ноогдол ашгийн орлого	1,670,336.9	4,616,412.8	2,946,075.90	176.4
Хүү, хөрөнгө оруулалтын орлого	14,591.9	14,477.8	(114.10)	-0.8
Валютын ханшийн ашиг алдагдал	(300,750.7)	(3,073,269.9)	(2,772,519.20)	921.9
7.Үйл ажиллагааны бус зардал	(40,238.0)	(571,317.4)	(531,079.40)	1319.8
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>149,920.0</b>	<b>450,749.2</b>	<b>300,829.20</b>	<b>200.7</b>
8.Татвар	1,459.2	1,447.8	(11.40)	-0.8

Ариг гал ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 171,9 сая төгрөгийн татвар шимтгэл төлсөн.

Үүнд: НӨАТатварт -21,4 сая төгрөг,  
 НДШимтгэлд -49,5 сая.төгрөг,  
 Газрын төлбөрт -34,3 сая төгрөг,  
 ҮХХТатварт -42,6 сая төгрөг,  
 ХАОАТатварт -22,6 сая төгрөг,  
 ААНОАТатварт -1,5 сая төгрөг тус тус төлсөн.

**Гурав. Өнгөрсөн оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт нь дараах биелэлттэй гарлаа.**

Үүнд: 2018 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан.

1. Шохойн чулуу олборлож борлуулах,
2. Компанийн сул чөлөөтэй байгаа газрыг түрээслүүлж, орлогоо нэмэгдүүлэх,
3. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч, үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж эргэлтийн хөрөнгийн зээл авахад дэмжлэг үзүүлнэ гэсэн чиглэлээр ажил үйлчилгээ хийлээ.



1. Шохойн чулуу

“Ариг гал” ХК-ийн шохойн чулууны ордны үйл ажиллагаанд 210,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 30,0 мянган м3 хөрс

хуулалтыг хийж, 15320 тн шохойн чулуу олборлож, 6320 тн-ыг шигшиж борлуулахад бэлэн болголоо.

Борлуулалт хийхээр судалж байна. Шохойн ордны ТЭЗҮ, БОННУ, менежментийн төлөвлөгөөг хийлгэхээр “Монслов” ХХК-тай гэрээ хийсэн бөгөөд гүйцэтгэл нь 70%-тай явж байна. 2019 оны 4-р сард хүлээн авна.

2019 онд үргэлжлүүлэн шохойн чулуу олборлох, борлуулах арга замыг олж ажиллахаас гадна ТЭЗҮ, БОННУ-г батлуулж, тэсэлгээ хийх эрхийг авах, түрээсийн тоног төхөөрөмжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

2. Компанийн сул чөлөөтэй байр талбайг ҮК-иудад түрээслүүлж, тэдний үйл ажиллагааг дэмжин ажиллах орчныг сайжруулах, ажилтнуудаа тогтвор сууршилтай ажиллуулах, борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх зорилгоор сүүлийн 10 жил хийгдээгүй бүтээн байгуулалтын ажил хийлээ.



Мон мяндас ХХК, Ариг оч ХХК-ийн ажилчдыг нэгтгэн гар сүлжих, автомат, оёх, гүйцэтгэн боловсруулалтын цехийг нүүлгэн шилжүүлж ажлын байрыг 2 дахин томсгож, Германы Штол 6ш машин, Японы SHIMA-SEIKI компанийн сүүлийн үеийн бүрэн автомат 14ш машин, Солнгоосоос оймсны 1ш машин, Италиас 30ш өндөр бүтээмжтэй оёх машин, тусгай зориулалтын зөөлөн оёдлын машиныг авч үйлдвэрлэлд 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, сүлжихийн хүчин чадлыг 2 дахин, гүйцэтгэн боловсруулахын хүчин чадлыг 2,4 дахин, зөөлөн оёдлын үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлж 300 гаруй шинэ ажлын байрыг бий болгож жилдээ 500 гаруй мянган ширхэг ноолуурын сүлжмэл, 5000 ш пальто үйлдвэрлэх хүчин чадалтай болсон.

АриггалХК нь үндэсний томоохон үйлдвэрлэгч, бүтээн байгуулагчдыг бий болгосны зэрэгцээ хөрөнгө оруулагчийн хувьд “Эвсэг” үйлдвэрийн дэлгүүрийг өргөтгөж 1700м<sup>2</sup> болгон Монголдоо төдийгүй, дэлхийд хамгийн том үйлдвэрийн дэргэдэх худалдааны төвийг ашиглалтанд оруулж, 383,3 сая.төг-ийн хөрөнгө оруулалт хийлээ.

“Эвсэг”-ийн худалдааны төв нь үйлдвэрлэлтэйгээ нэг дор зэрэгцэн оршдог, дэлгүүрт ирсэн гадаад, дотоодын худалдан авагч, жуулчид нь ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлд яаж боловсрогдож байгааг үйлдвэрлэлийн



шат дамжлагаар нь дэлгүүрээс нь шууд харах боломж, нөхцлийг бүрдүүлснээрээ, үйлдвэрийн дэргэдэх ноолуурын дэлгүүрүүд дотроос дэлхийд хамгийн том худалдааны төв болсон юм.

Ариг гал ХК-ийн ашиглалтгүй байсан 3096м<sup>2</sup> талбайд сүлжих оёх, гүйцэтгэн боловсруулах цехийг 1404м<sup>2</sup> талбайд анхан шатны үйлдвэрлэлийн ноолуур хадгалах, ширмэл зөөлөн оёдлын бүтээгдэхүүн хадгалах складыг байгуулснаас гадна 00-ийн засвар,

тамхины цэг, ажилчдын эрэгтэй, эмэгтэй өлгүүр, коридор, гуанз, албан өрөөнд засвар үйлчилгээ хийж, нийт 559,6 сая.төгрөгийн санхүүжилт хийсэн.


Тус үйлдвэрийн барилгын 3000 гаруй метр квадрат дээврийн засварын ажлыг шинэ технологи нэвтрүүлэн өөрсдийн хүчээр 174,7 сая. төгрөгөөр засвар хийлгэж хүлээн авлаа.

2018 онд дээврийн, барилгын засвар үйлчилгээнд нийт 1,2 тэрбум төгрөг, шинээр авсан тоног төхөөрөмжинд 3,5 тэрбум төгрөг, нийт 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж ажиллах орчин нөхцлөө сайжрууллаа.



3. Ариг гал ХК-ийн 2018 онд хийсэн бас нэг хамгийн том хөрөнгө оруулалт бол ажилчдаа тогтвор сууршилтай ажиллуулах зорилгоор 200 хүүхдийн цэцэрлэгийн байрыг 63,3 сая.төгрөгөөр засвар хийж бэлэн болгосноос гадна шаардлагатай тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, хүүхдийн тоглоом, дотоод тохижилт зохион байгуулалт хангамжинд 32,3 сая.төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

4. Ариг гал ХК-ийн сэлбэг борлуулахын тулд Эрдэнэт хивс ХХК-нд 10000ш патрон зарснаас гадна бусад үлдэгдэл сэлбэгийг авах талаар ярилцаж эхэлсэн. Компанийн хашаанд олон жил хураагдсан



хог, төмрийн  
төгрөгийн орлого

хаягдлыг ялгаж, төмрийн хаягдалд тушааж 11,0 сая.  
оруулсан.

5. Ариг гал ХК нь Удирдлагын академ, АПУ ХХК, Санкомфорт ХХК, MCS эстейтик ХХК, Орхон их сургууль, Цэцэрлэгийн талбай, стадионы түрээсийн төлбөрийг цаг тухайд нь дүгнэж 386,3 сая.төгрөгийн орлого оруулсан.

6. АПУ ХХК-тай олон жил маргаж байсан цахилгаан кабель татсан газраас газар эзэмшүүлсэн түрээсийн гэрээг хийж, эхний төлбөр 3,8 сая төгрөгийг авч орлого оруулсан.

7. Газартай холбоотой маргаануудыг тухай бүр таслан зогсоож хашааг шинээр барих, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тус компанийн ажилтнуудад Зуслангийн газар нэрээр авсан СХД-ийн 20-р хороонд байрлах 1 га газрыг сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулаагүй гэдэг шалтагаар гэрчилгээг сунгахгүй, хүчингүй болгоно гэсэн асуудлыг НГАЛбатай удаа дараа уулзаж, захирамжийг гаргуулан ажилтнуудын зуслангийн зориулалтаар зураг төсөв хийлгэх ажлыг эхлүүлж байна.

## **Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар**

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэц нь ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээр ажиллаж байгаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер ходдинг ХХК иуд харъялагддаг.

Кашмер холдинг ХХК-ийн харъяанд түүний охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд орж байгаа,

Группийн харъяа компаниудаас хувьцаагаар хөрөнгө оруулалттай Мон ноос ХК, Дорнод ноос ХК-иуд бас группийн харъяалалд хамаарагдан өргөн хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулж эдгээр бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого удирдлагаар хангаж ажилладаг.





ТУЗ-ийн даргын АА нь ТУЗ-д туслах чиг үүрэгтэй бөгөөд группийн харъяа компаниудыг ТУЗ-өөс явуулж байгаа удирдлага, менежментийн бодлогыг хэрэгжүүлэх, харъяа компаниудын ажлыг дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах асуудлыг ТУЗ-ийн даргад оруулж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулахад холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, түүний дагуу компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулах зэрэг ажлыг үр дүнд хүргэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаар группийн компаниудын хэмжээгээр 2018 онд өмнөх оноос орлого 16.1 хувиар, ашиг 49.4 хувиар өсч, 4.1 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалт оруулалт хийж шинээр 360 гаруй ажлын байрыг бий болгож, Улсын төсөвт 4.0 тэрбум гаруй төгрөгийн татвар шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос орлого 18%-иар, хөрөнгө оруулалт 2 дахин, улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө 60% -иар өссөн байна.

Манай хамт олон 2018 онд маш том бүтээн байгуулалт хийсэн нь ажилчдын ая тухтай нөхцлийг хангасан 1750 м2 ашигтай талбай бүхий сүлжих үйлдвэрлэлийн шинэ байр, 1700м2 талбай бүхий “Үйлдвэрийн дэргэдэх ноолуурын дэлгүүр”-ийн өргөтгөлийг ашиглалтад хүлээж авсан. Мөн барилгын дээврийн ажлыг шинэ технологиор гүйцэтгэж, ажлын туршлага хуримтлуулж, хос мэргэжил эзэмшсэн нь цаашид барилгын чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөх боломжийг бүрдүүллээ.

Группийн харъяа үйлдвэрлэлийн компаниуд нь эх орныхоо “сэргээгддэг баялаг” болсон Монгол ямааны ноолуураар олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тэдгээрээс цөөнгүй нэр төрлөөр гадаад, дотоодын нэр хүндтэй байгууллагуудын шагнал, өргөмжлөлийг хүртсээр ирсэн билээ. Зөвхөн өнгөрөгч онд гэхэд Монголын дизайнеруудын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Гоёл-2019” наадмаас манай дизайнерүүдийн баг “Шилдгийн шилдэг гранпри” –гээр шалгарсныг хувьцаа эзэмшигчиддээ сонордуулахад таатай байна.

Мөнхугацаанд ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 200-гаад ортой хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад орууллаа.

Группийн хэмжээнд ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллуулах, тэднийг ажлын үр дүнгээр нь хөхүүлэн дэмжихэд тогтвортой ажлын гэрээний болон бусад шагнал урамшуулалд давхардсан тоогоор **1173** ажилтныг **736.4** сая.төг-өөр урамшуулж, **135** ажилтанд **76.8** сая.төг-ийн буцалтгүй тусламж үзүүлсэн, **11** ажилтныг их дээд сургуульд сургаж компаниас **32.0** сая.төг-ийн сургалтын зардлыг санхүүжүүлсэн байгаа. Шинэ тоног төхөөрөмж суурилуулсантай холбоотойгоор программист инженерүүд, дизайнер, технологич инженерүүдийг Япон, Герман улсуудад,

сургасан.

Шинэ ажлын байранд **206** ажилтныг ажилд авсан.

### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь**

Өнөөдөр тус компанийн хувьцааг өнөөдөр 7371 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байна. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшдэг.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон МХБ,СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн байгаа.

Компани өөрийн хувьцааны 3.2%-ийг халаасласан байна. Бусад 44.4%-ийн хувьцаа нь 7367 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа болно.

### **Зургаа. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.**

Тус компани 2015 онд нийт ашгийн 60%-иар нэгж хувьцаанд 33.00 төг буюу нийт 114.8 сая.төг-ийг, 2016 онд нийт ашгийн 50%-иар, нэгж хувьцаанд 17.82 төгрөг буюу нийт 62.0 сая.төг-ийг, 2017 онд нийт ашгийн 50%-иар нэгж хувьцаанд 21.33 төгрөг буюу нийт 74.2 сая.төг-ийг нийтдээ 251.0 сая.төг-ийг 2018 онд нийтэд хуваарилан тараасан.

2018 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 32.48₮ -өөр буюу нийт 109,3 сая.төг-ийг хуваарилахаар ТУЗ-ийн 2019 оны 02 сарын 19-ны өдрийн 06/19 тоот тогтоолоор шийдвэрлэснийг өнөөдрийн ХЭХ-д оруулах гэж байна. Уг ногдол ашгийг 9 сараас хэтрүүлэхгүйгээр нийтүд зарлан тараах болно.

## Долоо. Цаашид хийх ажил

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж, эргэлтийн хөрөнгийн зээл авахад нь дэмжлэг үзүүлэх.
2. “Мон ноос” ХК-ийн оффисийн барилгад засвар хийж, тогтвор сууршилтай ажиллах, залуу гэр бүл болон компанид олон жил үр бүтээлтэй үнэн ч ажиллаж буй ажилтнуудыг оруулах ажлыг эхлүүлэх.
3. “Мон ноос” ХК-ийн тоног төхөөрөмжинд иж бүрэн засвар хийж, хонины ноос угааж компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх.
4. Компанийн сул чөлөөтэй байгаа байр талбай, газрыг түрээслүүлж орлого нэмэгдүүлэх зорилгыг тавьж ажиллаж байна.

Хүндэтгэсэн: Гүйцэтгэх захирал

Х.Хания





АРИГ ГАЛ ХК-ИЙН 2018 оны жилийн эцсийн БАЛАНС		
		(мян.төг-өөр)
БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн
<b>А.ХӨРӨНГӨ</b>		
1. Эргэлтийн хөрөнгийн дүн	36,140,880.1	36,592,342.2
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	338,324.6	216,261.0
Авлага	35,778,496.8	36,346,400.4
Үндсэн туслах материал	24,058.7	29,680.8
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
2. Биет хөрөнгийн дүн	2,868,525.3	2,945,485.9
Барилга байгууламж	4,424,365.4	4,424,365.4
Машин, тоног төхөөрөмж	7,142.0	7,142.0
Тавилга эд хогшил	55,747.1	55,747.1
Хуримтлагдсан элэгдэл	(1,619,429.2)	(1,627,468.6)
Бусад	700.0	85,700.0
3. Биет бус хөрөнгийн дүн	98,407.6	473,676.5
4.Урт хугацаатай хөрөнгө оруулалт	23,813,334.3	20,873,089.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>62,921,147.3</b>	<b>60,884,594.5</b>
<b>Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
1. Өр төлбөрийн дүн		
Богино хугацаат өр төлбөр	47,882,947.8	49,703,003.4
Урт хугацаат өр төлбөр	1,899,291.1	160,818.1
Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр		
2. Хувьцааны дүн	347,932.0	347,932.0
Энгийн хувьцааны тоо, ширхэг	3,479,320.0	3,479,320.0
Нэрлэсэн үнэ	0.1	0.1
Давуу эрхийн хувьцааны тоо, ширхэг	-	-
Нэрлэсэн үнэ		
Халаасны хувьцааны дүн	(9,142.8)	(9,142.8)
3. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,598,730.6	6,598,730.6
4. Хуримтлагдсан ашиг	6,052,927.8	3,633,951.8
Тайлант үеийн ашиг	148,460.8	449,301.4
5. Эзэмшигчийн өмчийн дүн	13,138,908.4	11,020,773.0
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>62,921,147.3</b>	<b>60,884,594.5</b>
Орлогын тайлан		
		(мян.төг-өөр)
Санхүүгийн үзүүлэлт	2017 он	2018 он
Борлуулалт	304,578.1	357,932.6
Борлуулалтын хөнгөлөлт, урамшуулал		
Цэвэр борлуулалт	304,578.1	357,932.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,462.1	-
<b>Ашиг</b>	<b>303,116.0</b>	<b>357,932.6</b>
Үйл ажиллагааны зардал	1,497,136.1	893,486.7
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	1,343,940.1	986,303.3
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>149,920.0</b>	<b>450,749.2</b>
Татвар	1,459.2	1,447.8

# “АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮГНЭЛТ

## Нэг. Санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдлаар талаар

Компанийн нийт хөрөнгө 60.9 тэрбум төгрөгт хүрч, тайлант жилийн хугацаанд 2.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ бууралт нь үндсэндээ урт хугацаат хөрөнгө оруулалтын бууралттай холбоотой байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд урт хугацаат өр төлбөрийн хэмжээг 1.7 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэн охин компаниудын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа учраас группийн доторх хоорондын тооцооны өглөг авлага, дийлэнх хувийг эзэлж байгаа боловч, авлагыг насжилтаар нь ангилан найдваргүй болсон хэсгийг данснаас хасах, өр төлбөрийн зарим хэсгийг холбогдох компанийн данс бүртгэлд шилжүүлэн бүртгэх зэргээр зохицуулалт хийх шаардлагатай байдал харагдаж байна. Гэхдээ авлагын үлдэгдэл 36,3 тэрбум төгрөг байхад богино хугацаат өр төлбөрийн 49,7 тэрбум төгрөг байгаа нь даруй 10 гаруй тэрбум төгрөгийн зөрүүтэй байгаагийн шалтгааныг гүйцэтгэх удирдлагын зүгээс тайланд тодорхой тусган дүн шинжилгээ хийж харуулаагүй хэвээр байна. Жил дараалан анхааруулсаар ирсэн боловч нийт хөрөнгийн 8,9 хувийг эзэлж буй бусад эргэлтийн бус хөрөнгийн талаарх тайлбараа санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй хэвээр байна.

Тайлангийн хугацаанд урт хугацаат зээлийн үлдэгдлийг 1,05 тэрбум төгрөгөөр бууруулсан нь компанийн санхүүгийн байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гаргахад хүргэсэн байна.

### Хоёр. Орлого

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг охин компаниудад шилжүүлж, үйл ажиллагааг нь зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг хангах зэргээр холдингийн толгой компанийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа учраас нь орлогын эх үүсвэр нь:

А. Ногдол ашиг 4,616,4 сая төгрөг

Б. Түрээсийн орлого 303,6 сая төгрөг

В. Хүүгийн орлого гэсэн хэлбэртэй байна. 14,5 сая төгрөг, нийт 4934,5 болж өнгөрсөн оныхоос ихээхэн өссөн боловч валютын ханшийн зөрүүгээс 3.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. Түрээсийн орлогын хувьд 386,3 сая төгрөгийн өсөлт байгаа нь инженерийн байгууламжийн шугам сүлжээний үйлчилгээ үзүүлэх үнэ тарифыг эрчим хүч болон бусад зардлын өсөлтийг



харгалзан түрээсийн үнэ тарифыг шинэчлэн тогтоосон, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг түрээслэх болсонтой холбоотой байна.

Мөн компанид олон жил хадгалагдсан цаашид ашиглах боломжгүй сэлбэг хэрэгсэлийг балансын үнээр нь охин компанид борлуулж, энэ асуудал үндсэндээ шийдвэрлэгдсэн гэж үзэж болохоор байна. Одоо үлдсэн хэсгийг хаягдал төмөрт шилжүүлэн борлуулах шаардлагатай байна.

### 3. Зардал

Тайлант онд үйл ажиллагааны зардлаа 606,3 сая төгрөгөөр буюу 40,3%-иар багасгаж адсаныг онцлон тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд зээлийн хүүгийн зардал 59,2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаа 44,4 сая төгрөгөөр, мөн хөрөнгийн элэгдлийг 114,6 сая төгрөгөөр тус тус бууруулсан, харин өссөн зардал нь цалингийн зардал 58,9 сая төгрөг, бусад зардал 19,5 сая төгрөг өссөн байна.

Санхүүгийн тайлан балансаас харахад өнгөрсөн 2018 онд төлөвлөсөн зардлаас 2,9%-иар бууруулсан нь зардлаа хэмнэх бодлого явуулсан нь харагдаж байна. Ноогдол ашгийн орлого 4,6 тэрбум төгрөг орж ирснээр ЧХБанкны үндсэн зээл 1,7 тэрбум төгрөгийг хүүтэй нь хамт төлж дуусгасан бөгөөд бусад зээлүүдээс 6 харилцагчийн зээлийг төлж дуусгавар болгосон.

### 4. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв

Санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны түвшингээс ахисан байна. Өнгөрсөн онд гадаад валютын ханшийн зөрүүнээс багагүй хэмжээний ашиг олж, санхүүгийн үйл ажиллагааны алдагдлыг нөхөж байсан энэ онд эсрэгээр санхүүгийн үйл ажиллагаанаас өндөр орлого олсон төдийгүй хөрөнгө оруулалтаар үйлдвэрл үйлчилгээг өргтөгх ажилны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэргээр сүүлийн жилүүдэд байгаагүй өндөр амжилт олж чадсан байна. Үүнд:

1. Мон мяндас ХХК, Ариг оч ХХК-ийн ажилчдыг нэгтгэн зарим цехийг нүүлгэн шилжүүлж ажлын байрыг 2 дахин томсгож, Германы Япон Италийн сүүлийн үеийн машин тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрлэлд 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний үр дүнд сүлжих хүчин чадлыг 2 дахин, гүйцэтгэн боловсруулах хүчин чадлыг 2,4 дахин, зөөлөн оёдлын үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлж, 300 гаруй шинэ ажлын байрыг бий болгож жилдээ 500 гаруй мянган ширхэг ноолуурын сүлжмэл, 5000 ш пальто үйлдвэрлэх хүчин чадалтай болжээ.
2. “Эвсэг” үйлдвэрийн дэлгүүрийг өргөтгөж 1700м<sup>2</sup> болгон Монголдоо төдийгүй Азид, магадгүй дэлхийд хамгийн томд орох Кашмер-ноолууран бүтээгдэхүүний “Супер-маркет” худалдааны төвийг ашиглалтанд

оруулж, 383,3 сая.төг-ийн хөрөнгө оруулалт хийлээ.

3. Ариг гал ХК-ийн ашиглалтгүй байсан 3096м<sup>2</sup> талбайд сүлжих оёх, гүйцэтгэн боловсруулах цехийг 1404м<sup>2</sup> талбайд анхан шатны үйлдвэрлэлийн ноолуур хадгалах, ширмэл зөөлөн оёдлын бүтээгдэхүүн хадгалах складыг байгуулснаас гадна 00-ийн засвар, тамхины цэг, ажилчдын эрэгтэй, эмэгтэй өлгүүр, коридор, гуанз , албан ерөөнд засвар үйлчилгээ хийж, нийт 559,6 сая.төгрөгийн санхүүжилт хийсэн.
4. Тус үйлдвэрийн барилгын 3000 гаруй метр квадрат дээврийн засварын ажлыг шинэ технологи нэвтрүүлэн өөрсдийн хүчээр 174,7 сая.төгрөгөөр засвар хийлгэж хүлээн авлаа.
5. Ажилчдаа тогтвор сууршлыг сайжруулах зорилгоор 140 хүүхдийн цэцэрлэгийн байрыг 63,3 сая.төгрөгөөр засварлаж, шаардлагатай тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, хүүхдийн тоглоом, дотоод тохижилт зохион байгуулалт хангамжинд 32,3 сая.төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.
6. Хэргэцээгүй, илүүдэл сэлбэг борлуулахын тулд Эрдэнэт хивс ХХК-нд 10000ш патрон зарснаас гадна бусад үлдэгдэл сэлбэгийг авах талаар ярилцаж байна. Хашаанд олон жил хураагдсан хог, төмрийн хаягдлыг ялгаж, төмрийн хаягдалд тушааж 11,0 сая.төгрөгийн орлого оруулсан.
7. Удирдлагын академ, АПУ ХХК, Снакомфорт ХХК, MCS эстейтик ХХК, Орхон их сургууль, Цэцэрлэгийн талбай, стадионы түрээсийн төлбөрийг цаг тухайд нь дүгнэж 386,3 сая.төгрөгийн орлого оруулсан.
8. АПУ ХХК-тай олон жил маргаж байсан цахилгаан кабель татсан газраас газар эзэмшүүлсэн түрээсийн гэрээг хийж, эхний төлбөр 3,8 сая төгрөгийг авч орлого оруулсан.
9. Газартай холбоотой маргаануудыг тухай бүр таслан зогсоож хашааг шинээр барих, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.
10. Компанийн ажилтнуудын Зуслангийн газрын зориулалтаар авсан СХД-ийн 20-р хороонд байрлах 1 га газрыг сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулаагүй гэдэг шалтагаар гэрчилгээг сунгахгүй, хүчингүй болгоно гэсэн асуудлыг НГАлбатай удаа дараа уулзаж, захирамжийг гаргуулан ажилтнуудын зуслангийн зориулалтаар зураг төсөв хийлгэх ажлыг эхлүүлжээ.



## Дүгнэлт

Өнгөрсөн жилийн тайлангаар үүрэг даалгаварууд үндсэндээ хэрэгжсэн байна.

Мөн түүнчлэн энэ жилийн үйл ажиллагааны тайлан нь өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад агуулгын хувьд дэлгэрэнгүй сайн болсныг тэмдэглэх нь зүйтэй.

ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан нь компанийн бодит байдлыг бүрэн зөв тусгасан бөгөөд гүйцэтгэх баг нь тавьсан зорилгоо үндсэнд нь биелүүлж сайн ажилласан гэсэн дүгнэлт өгснийг хувьцаа эзэмшигчдийн хурал танилцуулж байна.





Ариг гал ХХ-ийн ТУЗ-д нэр дэвшэгчдийн танилцуулга

Гийшүүнлэл	ТУЗ-ийн энгийн гишүүн	ТУЗ-ийн энгийн гишүүн	ТУЗ-ийн энгийн гишүүн	ТУЗ-ийн энгийн гишүүн	ТУЗ-ийн энгийн гишүүн	
Овог нэр	С.Мөнхжаргал	Х.Ханья	Д.Глевиалл	С.Алиава	Д.Мөнхбат	
Ажлын газар, албан тушаал	Кашмер Холдинг ХХК-ийн гүйцэтгэх захирал	Ариг гал ХК-ийн гүйцэтгэх захирал	Кашмер холдинг ХХК-ийн Бизнесийн үр дүн харуулсан Захирал	Диксийн концепт" ХХК-ийн ерөнхий захирал	Кашмер холдинг ХХК-ийн Маркетинг, борлуулалт эрхэлсэн захирал	
Хувилгатай хугацаа	1 жил	1 жил	1 жил	1 жил	1 жил	
Хувьцаа эзэмшил тэн хувь, хэмжээ	12.8	0.8	0.8	0.8	0.8	
Суралцсан байдал	1967-1977 онд ЕБС 1977-1984 онд ОХУ-ын Ленинград хотын нэхмэлийн үйлдвэрийн дээр сургуулийг Хөнгөн аж үйлдвэрийн инженер-механик мэргэжлээр төгссөн. Техникийн ухааны магистр.	1967-1982 ШУТИС-ийн МГАИ-ыг хөнгөн үйлдвэрийн механик инженер мэргэжлээр төгссөн. 1989 онд Болгар улсын Габрова хотын Витевс нэгдэл, 1983 онд Япон улсын Токио хотод олон улсын хамтэн ажиллагааны төвд мэргэжил дээшлүүлсэн.	1967-1977 онд ЕБС 1977-1984 онд ОХУ-ын Ленинград хотын нэхмэлийн үйлдвэрийн дээр сургуулийг инженер-механик мэргэжлээр төгссөн. 2005-2006 онд Англи улсын Bradford хотод загвар зохион бүтээгч мэргэжлээр суралцаж төгссөн.	1968-1979 онд ЕБС 1979-1984 онд Политехникийн дээд сургуулийг механик инженерээр төгссөн. 2005-2006 онд Англи улсын Bradford хотод загвар зохион бүтээгч мэргэжлээр суралцаж төгссөн.	1974-1984 онд ЕБС 1984-1989 онд МУ-ын техникийн их сургуулийг эрхэк үйлдвэрлэлийн технологийн инженер мэргэжлээр төгссөн. 1983 онд Англи улсад хэлний сургалтанд, 1997-1999 онд ХЕНГУ-ын Дреан хотын техникийн их сургуулийн "Олон улсын мастер"-ийн сургалтанд сурч техникийн ухааны магистр цолтой төгссөн.	
Ажлын туршлага	1984 оноос Зэрмэлтийн Үйлдвэрт механик инженер, ЕМЗХ-ийн дарга, Гадаад харилцааны хэлтсийн дарга, ерөнхий инженер, 1991 оноос ЭХХ-ийн гүйцэтгэх захирал, 1994-1996 онд МХБ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, 1996-1998 онд ХХААУ Байгдан зөвлөлийн гишүүн, 1996-2000 онд Нийслэлийн иргэдийн хурлын тэр түүлчээр сонгогдон ажилласан. 2009 оноос "Кашмер холдинг" ХХК-ийн гүйцэтгэх захирал, "Ээрлэлт" ХК-ийн ТУЗ-ын дарга, 2014 оны 6-р сараас "Ариг гал" ХК-ийн ТУЗ-ийн дарга	1982-1990 онд НҮН-ийн засвар механикийн чөхөд, механик инженер, 1991-2009 онд ЭХХ-ийн механик инженер, ерөнхий инженер, Үйлдвэр эрхэлсэн захирал, 2009 оноос Ээрлэлт ХК-ийн гүйцэтгэх захирал 2014 оны 06-р сараас Ариг гал ХК-ийн гүйцэтгэх захирал	1983-1990 онд зэрмэлтийн Үйлдвэрт чанарын урийд ласын инженер, Гадаад харилцааны хэлтсийн дарга, ерөнхий инженер, Үйлдвэр эрхэлсэн захирал, 1995-2002 онд Мөнхос ХК-ийн ТДЗ, 2003-2009 онд Ээрлэлт ХК-ийн ТДЗ, 2009 оноос Кашмер холдинг ХХК-ийн Б-ЭЗ, 2014 оноос Кашмер холдинг ХХК-ийн Групп ха руудсан оролцож захирал, 2017 оноос "Кашмер холдинг" ХХК-ийн бизнесийн үр дүн харуулсан захирал, 2019 оноос Гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн аудитор	1984 онд Зэрмэлтийн Үйлдвэрт ахлах мастер, механик инженер, 2006 оноос "Кашмер холдинг" ХХК-ийн-Ерөнхий дизайнер, 2015 оноос "Дижитал концепт" ХХК-д ерөнхий захирал	1989-1995 онд Ноосны Үйлдвэрчин ШУТ төвд эрдэм шинжилгээний ажилтан, 1995-1997 онд Ээрлэлт ХК-д технологийн инженер, нарийн захирал Үйлдвэрлэлийн дарга, 1999-2003 онд Үйлдвэр технологийн хэлтсийн дарга 2003 оноос суржигч үйлдвэрлэлийн дарга, 2006-2009 онд "Мон мяндаас" ХХК-ийн гүйцэтгэх захирал 2009 оноос "Кашмер холдинг" ХХК-ийн маркетинг борлуулалт эрхэлсэн захирал, 2019 оноос Кашмер холдинг ХХК-ийн Бизнесийн үр дүн харуулсан захирал	1989-1995 онд Ноосны Үйлдвэрчин ШУТ төвд эрдэм шинжилгээний ажилтан, 1995-1997 онд Ээрлэлт ХК-д технологийн инженер, нарийн захирал Үйлдвэрлэлийн дарга, 1999-2003 онд Үйлдвэр технологийн хэлтсийн дарга 2003 оноос суржигч үйлдвэрлэлийн дарга, 2006-2009 онд "Мон мяндаас" ХХК-ийн гүйцэтгэх захирал 2009 оноос "Кашмер холдинг" ХХК-ийн маркетинг борлуулалт эрхэлсэн захирал, 2019 оноос Кашмер холдинг ХХК-ийн Бизнесийн үр дүн харуулсан захирал
Бусад мэдээлэл	Орос хэлтэй.	Орос хэлтэй.	Орос хэлтэй.	Англи хэлтэй.	Герман, Англи хэлтэй.	

Ариг гал ХК-ийн ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга

Гшиүүчлэл	ТУЗ-ийн энгийн гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Овог	Бардарч	Бямбажав	Эрдэнэ	Базар
Нэр	Ёндонжамц	Болд	Бямбажав	Аюуш
Ажлын газар, албан тушаал	"Булган кашмер" ХХК-ийн зөвлөх	Эрх зүйн статус ХХК-ийн ерөнхий захирал	Их тусч ХХК-ийн ерөнхий захирал	Дархистал ХХК-ийн захирал
Хүчинтэй хугацаа	1 жил	1 жил	1 жил	1 жил
Хувьцаа эзэмшилтэн хувь хэмжээ	0.01	0.06	0	0
Суралцсан байдал	1952-1962 онд ЕБС 1962-1967 онд Москва хотын нэмэлтийн дээд сургуулийг машин үйлдвэрлэлийн инженер механикаар төгссөн. 1976 онд Японд "ЛСА"-ийн шугамаар ннос, ноолуурын техник технологийн судалгаа 1983 онд АНУ-ын Калорид мужид ЭЗ-н дээд курс төгссөн.	1962-1972 онд ЕБС 1972-1977 онд ОХУ-ын Кубаны их сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн.	1948-1959 онд ЕБС 1959-1963 онд ОХУ-ын Эрхүү хотын УАААДС-ийг эзэлийн эдийн засагчаар төгссөн Английн Лидс хотод Англи хэлний Москва хотод ЭЗ-н академийн курс, Японы Токиод ОУ-н валютын сангийн курс төгссөн	1971 онд ЕБС 1971-1975 онд МУИС-ийг эдийн засагч, ня-66 мэргэжлээр төгссөн 1992 онд ОХУ-ын Москва хотын Пелехановын эдийн засгийн академид Эрдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2008-2012 онд МУИС-ийн хуулийн сургуулийг эрх зүйчээр суралцаж төгссөн
Ажлын туршлага	1967-1968 онд ХУ ТМС-д баши, 1970-1975 онд засвар угсралтын Үйлдвэр инженер Үйлдвэр рийн дарга, 1975-1978 онд ХХУ-нд ХХУ-д мэргэжилтэн. 1978-1986 онд ноолуур боловсруулах комбинат Говь ХК-ийн захирал, 1986-1990 онд НҮН-ийн дарга, 1996 оноос Ноос импекс ХХК-ийн ерөнхий захирал, 2000-2004 онд Говь ХК-ийн гүйцэтгэх захирал, 2007-2016 онд "Калимер холдинг" ХХК-ийн I орлогч захирал. 2016 оноос "Булган кашмер" ХХК-ийн зөвлөх	1977-1983 онд НАХЯ-ны 3-р хэлтэст, 1984-1987 онд СБД-ийн ерөнхий шүүгч, 1987-1990 онд УДШ-д Хд, 1990-1993 онд ерөнхийлөгчийн тамгын газар референт, 1993 оноос Гарнит ХХК-ийн дэд захирал, 1996 оноос хойш "Эрх зүйн статус" ХХК-ийн ерөнхий захирал	1963-1967 онд улсын банкнд мэргэжилтэн. 1967-1971 онд СЯ-нд Хд, 1972-1978 онд СЯ-ны I орлогч сайд, 1978-1979 онд МАХН-ын төв хороонд Хд, 1979-1984 онд Сангийн сайд, 1985-1989 онд УСУХ-ны дарга, 1989-1990 онд ГЗЗХХорооны I-р орлогч, 1992-1996 онд Сангийн сайд, 1997 оноос хойш "Их тусч" ХХК-ийн захирал	1975-1977 онд Тонот төхөөрөмжийн ерөнхий газарт орлогч ня-60, 1977-1994 онд МУИС-д баши, 1994-2011 онд СЗХ-ны ҮЦГ-т хэлтсийн дарга, газрын орлогч, 2011 оноос "Дархистал" ХХК-ийн захирал
Бусад мэдээлэл	Англи, Орос хэлтэй.	Орос, Англи хэлтэй	Орос, Англи хэлтэй.	Орос, Англи хэлтэй МУ-ын мэргэшсэн Ня-60



**NIRUN**

MONGOLIAN CASHMERE

# THE COAT

100% CASHMERE